



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/112/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Дорноговь аймаг Сайншанд
сум)

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: .70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: injig78@yahoo.com

Аудитор: Б.Отгон-Өлзий

Утас: 99844655 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	
3		
2	Аудитын тайлан	
5		
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	
2.11.	Шилэн дансны мэдээлэл	
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	
3	Менежментийн захидал	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.28 № 1-6/139
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөл/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Н.Энхмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 сарын 25-ны өдрөөс 2020 оны 01 сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ийн аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 сарын 07-ны өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн эрхэм зорилго нь Ус, цаг уур байгаль орчны мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн гамшиг орчны ноцтой бохирдлоос сэрэмжлүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ус цаг уурын эрдэм шинжилгээ

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 826,077.2 мянган төгрөгөөс тооцон 16,521.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,148.7 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	296.2		
Урьдчилгаа			
Бараа материал	100,051.9	117,750.6	17,698.7
Үндсэн хөрөнгө	918,051.5	954,249.8	36,198.3
Нийт хөрөнгө	744,096.7	758,245.3	14,148.7
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	744,096.7	758,245.3	14,148.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	744,096.7	758,245.3	14,148.7

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд нэмэлт санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг авлагаар бүртгэн тайлагнан, тайлант онд улсын төсвөөс буцаан авч зарцуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай зориулалтын материалын үлдэгдэл 12,000.2 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгслийн үлдэгдэл 1,296.0 мянган төгрөгөөр бусад хангамжийн материалын үлдэгдэл 2,024.0 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ. Бүх нэр төрлийн бараа материал бүрэн ашиглагдах буюу ашиглагдаж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь авто тээврийн хэрэгсэл 30,000.0 мянган төгрөгөөр, тоног төхөөрөмж 6,356.3 мянган төгрөгөөр нэмэгдэж бэлтгэгдснээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар БОАЖС-ын А/461 дүгээр тушаалаар 30,000.0 мянган төгрөгөөр авто машин авсан, 8,494.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг ЦУОШГ-ын даргын 2019 оны А/367 тушаалаар дээд газраас шилжүүлэн авсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлөөр ЦУОШГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар 2,296.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж акталж, хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 758,245.3 мянган төгрөг болж 14,148.7 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө 17,698.7 мянган төгрөгөөр өсч, 2,296.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв тайлант онд 100.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 247.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 247.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах аж ахуйн орлого	100.0	247.3	147.3	247,3

Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 147.3 мянган төгрөгөөр давсан нь орлогын төлөвлөгөөг бодиттой үнэн зөв төлөвлөдөггүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 727,403.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 727,317.8 мянган төгрөгийг урсгал зардалд, зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 727,303.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 100.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын төлөвлөгөөг бодиттой үнэн зөв төлөвлөдөггүй алдаа байна.

Давсан орлого 147.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Урсгал зардлыг нийт дүнгээр нь 85.6 мянган төгрөгөөр хэмнэсэн нь шуудан холбоо интернетийн зардлыг 4.7 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 5.6 мянган төгрөгөөр, даатгалын үйлчилгээний хөлсийг 7.9 мянган төгрөгөөр, тээврийн хэрэгслийн татварыг 4.7 мянган төгрөгөөр, цалин хөлс, урсгал засвар, бусад зардлуудыг 0,8-2.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 20,000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 17,456.8 мянга, нийт 37,472.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 21,000,0 мянган төгрөгөөр авто машин, эд хогшил худалдан авч 5,697.5 мянган төгрөгийг урсгал засварын зардалд, 3,092.0 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардал, 3.190.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшуулалд, 1,200.0 мянган төгрөгийг нормын хувцас авахад, 1,008.0 мянган төгрөгийг албан томилолтын зардалд, 123.3-422.0 мянган төгрөгийг гэрэл цахилгаан, хог хаягдал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд тус тус зарцуулж улсын төвлөрсөн төсөвт 19.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 12,796.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 10,000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 0 мянган төгрөгийн зөрчилд 0 акт тогтоож, 0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2,796.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 12,796.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

БОАЖЯамнаас хөрөнгө оруулалтаар авсан Mistubishi L200 маркийн авто машиныг орлого авч, бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалтыг заавал бүртгэх” заалт, УСНББОУС 17-ийн 19 дэх заалттай нийцэхгүй тохиолдсон байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн 2,796.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь 6 хугацаа хоцроож 0 мэдээлэл байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 71.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 71.5 мянган төгрөгийг барагдуулсан, 227.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 227.3 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Бараа материал, үндсэн хөрөнгийн ангилал буруу бүртгэгдсэн тухайлбал: 500.0 мянган төгрөгийн үнэтэй чанга яригч, 210.9 мянган төгрөгийн хэвлэгчийг аж ахуйн материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Үнэлгээ, Үнэн зөв байдал, Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3."Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Хөрөнгийн эдийн засгийн ирээдүйн өгөөж, үйлчилгээний чадамж дутуу үнэлэгдэж хөрөнгө ашиглагдаж, шамшигдах эсрэлтэй

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг бараа, материалын данснаас хөрөнгөнд ангиллын дагуу шилжүүлж бүртгэх, бараа материалын ангиллыг зөв ангилж бүртгэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Акталсан хөрөнгийг устгал хийлгүйгээр данснаас хассан

Энэ нь Үнэн зөв байдал, Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 13.3.3 “Засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж, устгах” заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Актлагдсан ашиглалтгүй үндсэн хөрөнгө агуулахад ашиглагдах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Акталсан хөрөнгийг устгал хийж данс, бүртгэлээс хасах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.3 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.3.1 Илрүүлэлт:

1996 онд үйлдвэрлэгдсэн Ланд 80 авто машиныг албан ажлын хэрэгцээнд ашигладаг

Энэ нь Үнэн зөв байх, Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Батлагдсан төсөв хэтрээгүй боловч Засгийн газраас тогтоосон өдөрт явбал зохих км, цилиндрийн багтаамжтай холбоотой норм нормативыг зөрчих

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Дээд шатны байгууллагадаа танилцуулж, авто машины хэрэглээг хязгаарлах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>100,348,029.11</u>	<u>117,750,558.27</u>
33	АВЛАГА	296,150.38	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	296,150.38	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	100,051,878.73	117,750,558.27
351	Түүхий эд материал	66,844,875.03	78,845,064.57
35110	Тусгай зориулалттай материал	66,844,875.03	78,845,064.57
354	Хангамжийн материал	22,802,903.70	27,687,293.70
35410	Бичиг хэргийн материал	142,750.00	210,350.00
35420	Аж ахуйн материал	12,900,159.00	14,919,749.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,773,368.00	4,069,368.00
35440	Түлш, шатах тослох материал	2,954,000.00	3,058,600.00
35450	Барилгын засварын материал	1,431,400.00	804,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,601,226.70	4,625,226.70
35600	Мал амьтад	10,404,100.00	11,218,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>643,748,628.70</u>	<u>640,494,794.47</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	643,748,628.70	640,494,794.47
392	Биет хөрөнгө	328,835,628.70	325,581,794.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	293,088,238.04	293,088,238.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	-20,490,156.54	-33,202,578.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	17,780,000.00	47,780,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,113,333.28	-14,696,666.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	258,889,855.62	265,246,165.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	-223,602,870.90	-240,653,522.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,165,787.36	18,007,787.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,859,084.73	-14,239,822.29
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,410,400.00	14,410,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,433,206.87	-10,158,206.91
393	Биет бус хөрөнгө	314,913,000.00	314,913,000.00
39301	Програм хангамж	804,248.50	804,248.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	-804,248.50	-804,248.50
39303	Бусад биет бус хөрөнгө	314,913,000.00	314,913,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>744,096,657.81</u>	<u>758,245,352.74</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>744,096,657.81</u>	<u>758,245,352.74</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	744,096,657.81	758,245,352.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	579,145,672.30	579,145,672.30

Дорноговь аймгийн УЦУОШТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51101	Өмч: - төрийн	579,145,672.30	579,145,672.30
512	Хуримтлагдсан үр дүн	-13,309,679.79	839,015.14
51210	Өмнөх үеийн үр дүн	-13,309,679.79	-3,309,679.79
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	4,148,694.93
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	178,260,665.30	178,260,665.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>744,096,657.81</u>	<u>758,245,352.74</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	729,677,101.36	830,225,894.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,987,601.36	65,710,445.28
120	Нийтлэг татварын бус орлого	60,987,601.36	65,710,445.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	60,864,653.86	65,710,445.28
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	110,000.00	247,330.38
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	60,754,653.86	65,463,114.90
120009	Бусад орлого	122,947.50	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	668,689,500.00	764,515,449.62
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	637,296,500.00	727,303,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	637,296,500.00	727,303,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,393,000.00	37,212,049.62
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,393,000.00	17,212,049.62
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	724,180,406.39	826,077,199.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	724,180,406.39	826,077,199.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	722,872,642.60	822,618,928.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	525,125,835.10	603,421,222.00
210101	Үндсэн цалин	451,246,435.10	502,120,922.00
210102	Нэмэгдэл	50,553,000.00	77,973,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,326,400.00	23,326,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,015,600.00	75,374,596.68
210201	Тэтгэврийн даатгал	42,010,400.00	51,291,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,251,300.00	6,034,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,201,000.00	4,827,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,050,300.00	1,206,800.00

Дорноговь аймгийн УЦУОШТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	10,502,600.00	12,015,196.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,374,467.00	24,180,951.62
210301	Гэрэл, цахилгаан	9,406,147.00	9,858,991.00
210302	Түлш, халаалт	13,928,320.00	12,739,160.62
210303	Цэвэр, бохир ус	1,040,000.00	1,582,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,074,338.36	23,671,915.09
210401	Бичиг хэрэг	1,629,646.00	1,848,580.00
210402	Тээвэр, шатахуун	6,575,302.00	10,792,434.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,190,705.61	2,243,581.73
210404	Ном, хэвлэл	7,355,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	348,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	866,380.00	1,817,650.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	5,109,304.75	6,729,668.46
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,805,893.08	38,218,870.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,007,948.08	33,728,912.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	181,920.00	234,400.00
210604	Урсгал засвар	7,616,025.00	4,255,558.00
2107	Томилолт, зочны зардал	3,995,800.00	4,998,300.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	3,995,800.00	4,998,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,445,497.50	9,029,509.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,421,507.50	7,307,112.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	481,000.00	496,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	309,240.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	145,037.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	572,000.00
210807	Газрын төлбөр	542,990.00	178,120.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,035,211.56	43,723,564.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	989,000.00	1,975,420.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,046,211.56	41,748,144.23
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,307,763.79	3,458,271.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,059,000.00	3,190,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,059,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,190,000.00

Дорноговь аймгийн УЦУОШТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	248,763.79	268,271.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	248,763.79	268,271.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,496,694.97	4,148,694.93
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	39,159,960.00	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	39,159,960.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-39,159,960.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-33,663,265.03	4,148,694.93

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	671,803,109.88	765,058,930.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	232,947.50	247,330.38
120	Нийтлэг татварын бус орлого	232,947.50	247,330.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	110,000.00	247,330.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	110,000.00	247,330.38
120009	Бусад орлого	122,947.50	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	671,570,162.38	764,811,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	637,296,500.00	727,303,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	637,296,500.00	727,303,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,273,662.38	37,508,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,273,662.38	17,508,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	670,110,109.88	745,058,930.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	670,110,109.88	745,058,930.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	668,506,195.71	741,600,659.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	525,125,835.10	603,421,222.00
210101	Үндсэн цалин	451,246,435.10	502,120,922.00
210102	Нэмэгдэл	50,553,000.00	77,973,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,326,400.00	23,326,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,015,600.00	75,374,596.68
210201	Тэтгэврийн даатгал	42,010,400.00	51,291,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,251,300.00	6,034,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,201,000.00	4,827,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,050,300.00	1,206,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,502,600.00	12,015,196.68

Дорноговь аймгийн УЦУОШТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,314,167.00	24,285,551.62
210301	Гэрэл, цахилгаан	9,215,575.00	9,858,991.00
210302	Түлш, халаалт	14,008,592.00	12,843,760.62
210303	Цэвэр, бохир ус	1,090,000.00	1,582,800.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,391,345.61	12,282,947.73
210401	Бичиг хэрэг	1,734,546.00	1,744,180.00
210402	Тээвэр, шатахуун	6,558,602.00	7,150,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,399,867.61	2,243,581.73
210404	Ном, хэвлэл	7,355,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	348,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	995,330.00	904,586.00
2105	Нормативт зардал	4,228,960.00	1,723,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,228,960.00	1,723,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,748,095.00	11,069,212.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,433,140.00	2,421,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	469,455.00	473,792.00
210604	Урсгал засвар	7,845,500.00	8,174,420.00
2107	Томилолт, зочны зардал	3,995,800.00	4,998,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,697,393.00	7,856,909.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,673,403.00	6,155,232.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	481,000.00	496,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	309,240.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	145,037.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	572,000.00
210807	Газрын төлбөр	542,990.00	157,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	989,000.00	588,920.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	989,000.00	588,920.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,603,914.17	3,458,271.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,059,000.00	3,190,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,059,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,190,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	544,914.17	268,271.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	544,914.17	268,271.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,693,000.00</u>	<u>20,000,000.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,693,000.00	20,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,693,000.00	20,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,693,000.00	20,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,693,000.00	20,000,000.00

Дорноговь аймгийн УЦУОШТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,693,000.00</u>	<u>-20,000,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,232,672.30	103,026,064.30	37,925,697.76	405,184,434.36
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	264,232,672.30	00.00	38,578,734.44	302,811,406.74
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-18,225,149.20	-18,225,149.20
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,145,672.30	178,260,665.30	-13,309,679.79	744,096,657.81
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,145,672.30	178,260,665.30	-13,309,679.79	744,096,657.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	10,000,000.00	10,000,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	579,145,672.30	178,260,665.30	-3,309,679.79	754,096,657.81
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,148,694.93	4,148,694.93
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,145,672.30	178,260,665.30	839,015.14	758,245,352.74

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны	үйцэтгэл	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	637,396,500.00	637,280,683.71	727,403,400.00	727,317,848.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	637,396,500.00	637,280,683.71	727,403,400.00	727,317,848.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭН	637,396,500.00	637,280,683.71	727,403,400.00	727,317,848.03

Дорноговь аймгийн УЦУОШТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ИЙ ЗАРДАЛ				
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	525,129,200.00	525,125,835.10	603,423,900.00	603,421,222.00
210101	Үндсэн цалин	451,249,800.00	451,246,435.10	502,123,600.00	502,120,922.00
210102	Нэмэгдэл	50,553,000.00	50,553,000.00	77,973,900.00	77,973,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,326,400.00	23,326,400.00	23,326,400.00	23,326,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,015,600.00	63,015,600.00	75,427,800.00	75,374,596.68
210201	Тэтгэврийн даатгал	42,010,400.00	42,010,400.00	51,291,000.00	51,291,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,251,300.00	5,251,300.00	6,034,200.00	6,034,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,201,000.00	4,201,000.00	4,827,400.00	4,827,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,050,300.00	1,050,300.00	1,206,800.00	1,206,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,502,600.00	10,502,600.00	12,068,400.00	12,015,196.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,343,500.00	24,314,167.00	24,163,500.00	24,162,260.62
210301	Гэрэл, цахилгаан	9,434,700.00	9,406,367.00	9,735,700.00	9,735,700.00
210302	Түлш, халаалт	13,444,200.00	13,444,200.00	12,844,200.00	12,843,760.62
210303	Цэвэр, бохир ус	1,463,600.00	1,463,600.00	1,583,600.00	1,582,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,989,000.00	8,984,793.61	8,534,000.00	8,528,947.73
210401	Бичиг хэрэг	1,144,200.00	1,143,546.00	1,744,200.00	1,744,180.00
210402	Тээвэр, шатахуун	4,058,600.00	4,058,600.00	4,058,600.00	4,058,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,403,300.00	3,399,867.61	2,248,300.00	2,243,581.73
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	382,900.00	382,780.00	482,900.00	482,586.00
2105	Нормативт зардал	1,223,800.00	1,222,000.00	523,800.00	523,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,223,800.00	1,222,000.00	523,800.00	523,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,145,900.00	4,141,095.00	4,375,000.00	4,371,692.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,346,400.00	1,346,140.00	1,421,400.00	1,421,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	474,000.00	469,455.00	474,000.00	473,792.00
210604	Урсгал засвар	2,325,500.00	2,325,500.00	2,479,600.00	2,476,900.00
2107	Томилот, зочны зардал	3,995,900.00	3,995,800.00	3,995,900.00	3,990,300.00
210702	Дотоод албан	3,995,900.00	3,995,800.00	3,995,900.00	3,990,300.00

Дорноговь аймгийн УЦУОШТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ТОМИЛОЛТ				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,964,600.00	5,892,393.00	6,370,500.00	6,356,909.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,068,800.00	5,068,403.00	4,656,300.00	4,655,232.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	481,000.00	481,000.00	496,000.00	496,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00	317,100.00	309,240.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	00.00	149,700.00	145,037.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	00.00	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	572,000.00	572,000.00
210807	Газрын төлбөр	00.00	00.00	157,400.00	157,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	589000.00	589000.00	589000.00	588920.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	589000.00	589000.00	589,000.00	588,920.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛ ЭХ ЭХ ҮҮСВЭР	637,396,500.00	637,280,683.71	727,403,400.00	727,317,848.03
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	637,396,500.00	637,280,683.71	727,303,400.00	727,070,517.65
131001	Улсын төсвөөс санхүүжих	637,396,500.00	637,280,683.71	727,303,400.00	727,070,517.65
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГ БН ҮЙЛ АЖИЛЛАГААН ААС	100,000.00	110,000.00	100,000.00	247,330.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	110,000.00	100,000.00	247,330.38
62	АЖИЛЛАГСАД БН ТОО			66	66.
620001	Удирдах ажилтан			5	5
620002	Гүйцэтгэх ажилтан			54	54
620003	Үйлчлэх ажилтан			7	7

4.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /НЭМЭЛТ ДАНС/

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	Гүйцэтгэл
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		33,977,512.00	37,492,250.00	37,472,811.00
УРСГАЛ ЗАРДАЛ		33,977,512.00	37,492,250.00	37,472,811.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		32,918,512.00	34,292,250.00	34,282,811.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал			130,250.00	123,291.00
Гэрэл, цахилгаан			130,250.00	123,291.00
Хангамж, бараа материалын зардал		11,406,552.00	3,754,000.00	3,754,000.00
Бичиг хэрэг		591,000.00		
Тээвэр, шатахуун		2,500,002.00	3,092,000.00	3,092,000.00
Ном хэвлэл		7,355,000.00		
Хог хаягдал зайлуулах		348,000.00	240,000.00	240,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		612,550.00	422,000.00	422,000.00
Нормативт зардал		3,006,960.00	1,200,000.00	1,200,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		3,006,960.00	1,200,000.00	1,200,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		16,300,000.00	26,700,000.00	26,700,000.00
Багаж, техник, хэрэгсэл		10,780,000.00	21,000,000.00	21,000,000.00
Урсгал засвар		5,520,000.00	5,700,000.00	5,697,520.00
Томилолт, зочны зардал			1,008,000.00	1,008,000.00
Дотоод албан томилолт			1,008,000.00	1,008,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,805,000.00	1,500,000.00	1,500,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,605,000.00	1,500,000.00	1,500,000.00
Газрын төлбөр		200,000.00		
Бараа үйлчилгээний бусад зардал		400,000.00		
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		400,000.00		
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,059,000.00	3,200,000.00	3,200,000.00
Бусад урсгал шилжүүлэг		1,059,000.00	3,200,000.00	3,200,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал		1,059,000.00		
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал			3,200,000.00	3,200,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		34,273,662.38	37,456,861.00	37,472,811.00

Дорноговь аймгийн УЦУОШТөвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нэмэгдэл санхүүжилтийн орлого		34,273,662.38	37,456,861.00	37,472,811.00
Дээд шатны төсөв захирагчаас		10,000,000.00	20,000,000.00	20,000,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого		24,273,662.38	17,456,861.00	17,472,811.00